



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/263

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагаын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалт, мөн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан Гудамж, зам талбайн гэрэлтүүлэг (Булган сум 4 дүгээр баг)-ийн ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах 150,000,000 (Нэг зуун тавин сая) төгрөгний төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д олгосугай.

2.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр зохион байгуулж, тайланг сар бүрийн 25-ны дотор Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д үүрэг болгосугай.

3.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010245